



DPUB

Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл



Мэдээллийн эмхэтгэл №3
2017 он 11-р сар

Багануур дүүргийн удирдах ажилтны сургалт

2017.11.7

Багануур дүүрэг ХБИ, өндөр настан, хүүхэд гээд бүх хүмүүс ая тухтай амьдрах боломжтой дүүрэг болохоор зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлыг



удирдах ажилтнууд зөв ойлгосны үндсэн дээр тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр ажиллах нь чухал юм. Тиймээс тус дүүргийн ЗДТГ, ХНХЯ болон ЖАЙКА-ийн төсөлтэй хамтран удирдах ажилтны сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд 80 гаруй удирдах албан тушаалтан хамрагдсан юм Сургалт 9 цагаас 17 цаг хүртэл үргэлжилсэн ба удирдах албан хаагчдын ойлголт, хандлагыг өөрчлөх

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Түгээмэл загвар гэх мэт сэдвүүдээр явагдлаа. Оролцогчид тус сургалтанд маш идэвхтэй оролцсон бөгөөд DET сургалтын үеэр хөгжлийн бэрхшээлийн талаар харилцан ярилцаж, бэрхшээл нь нийгэм, хүрээлэн буй орчинд байдаг юм байна гэдэг ойлголттой болсон.

Дүүргийн засаг дарга Ц.Сандаг-Очир тус сургалтанд бүтэн өдрийн турш идэвхтэй оролцсон нь бидний хувьд талархуштай явдал боллоо. Сургалтын гол зорилго нь “ХБИ амьдрахад таатай нийгэм гэдэг нь бүх хүн амьдрахад таатай нийгэм” гэсэн ойлголтыг өгөх явдал байлаа. ХБИ-д халамж, туслалцаа үзүүлэхээс гадна тэдний амьдрахад таатай нийгмийг бий болгосноор өндөр настан, хүүхэд,



жирэмсэн эх, дотоод, гадаадын жуулчин, хүүхдийн тэрэг түрээд явж байгаа ээжүүд, унадаг дугуйтай хүн гээд бүх л хүмүүс ая тухтай амьдрах боломжтой болно.

Энэ удаагийн сургалтыг хамтран зохион байгуулсан Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын хамт олон, сургалтанд оролцсон удирдах албан тушаалтнууд, DET сургалтын сургагч багш нарт талархал илэрхийлье. Багануур дүүрэг “Бүх хүмүүс амьдрахад таатай” дүүрэг болж өөрчлөгдөнө гэдэгт найдаж байна.



Сайн байцгаана уу, та бүхэнтэй дахин мэндчилж байгаадаа баяртай байна. Миний хувьд Монголд ажиллаад 2 дахь өвөлтэйгээ золгож байна. Өнгөрсөн жил Монголын өвөлд нэлээд дассан болохоор энэ жилийн хүйтнийг ажрахгүй давах байх аа гэж бодсон чинь өвөл дөнгөж эхлээд байхад ханиад хүрчихлээ. Ойрын үед хүйтэрч байгаа учраас та бүхэн ч гэсэн эрүүл мэндээ бодож дулаан хувцаслаарай.

Энэ удаа би хөгжлийн бэрхшээлийн салбарт яагаад ажиллах болсон тухайгаа бичье. Би их сургуульд математикийн шинжлэх ухааны чиглэлээр суралцаж, инженерийн мэргэжил эзэмшсэн. Сургуулиа төгсөөд 4 жилийн хугацаанд инженерээр ажилласан боловч нэг л сонирхолгүй санагдаад ажлаасаа гарахаар шийдсэн. Тэгээд ямар ажил хийх вэ гэж удаан бодсоны эцэст НҮБ-д ажиллахаар шийдсэн юм. НҮБ-д ажиллана гэж бодохоор нэг л гоё байгаа биз дээ?

Гэвч миний эргэн тойронд НҮБ-д ажилладаг хүн байхгүй байсан учраас тэнд ажилд орохын тулд юу хийх ёстой талаар ямар ч мэдээлэлгүй байлаа. Ямар ч л байсан англи хэлтэй, бас магистрын зэрэг хамгаалсан байх хэрэгтэй гэж бодоод гадагшаа сургуульд явахаар боллоо. Тухайн үед миний англи хэлний мэдлэг тийм ч сайнгүй байсан учраас эхлээд англи хэлний сургуульд суралцах шаардлага гарсан. Гэтэл сургалтын төлбөр нь гайхмаар өндөр өртөгтэй байлаа. Тийм учраас би хурдан хугацаанд хэлний мэдлэгээ дээшлүүлэхийн тулд шаргуу хичээллэх болсон. Тэр үед л би мөнгө байхгүй хүн шаргуу хичээллэдэг юм байна аа гэдгийг ойлгосон юм. Тэгээд 1 жил эрчимтэй хичээллэсний дүнд Австралийн их сургуульд элсэн орж чадсан. (Үргэлжлэлийг дараагийн дугаарт...)



JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй.

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **919** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Мөрөөдлийн SetTopBox

2017.11.6

Та бүхэн телевизийн нэвтрүүлэг үзэхдээ үсгэн тайлбар (subtitle), дохионы хэлний орчуулгыг нэмэлтээр оруулбал бүх хүнд хүртээмжтэй болно гэж боддог уу?

Япон улсын хувьд телевизийн нэвтрүүлгүүдийн 60% нь үсгэн тайлбартай гардаг. Харин Монгол улсын хувьд ихэнх нэвтрүүлгүүдэд үсгэн тайлбар байдаггүй бөгөөд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз (MNB)-ийн мэдээллийн хөтөлбөр л өдөрт 1 цагийн дохионы хэлний орчуулгатай гардаг. Тийм учраас сонсголын бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудаас холбогдох байгууллагуудад телевизийн нэвтрүүлэгт үсгэн тайлбар, дохионы хэлний орчуулгыг нэмэлтээр оруулах хүсэлт тавьж ирсэн боловч бодитоор хэрэгжээгүй хэвээр байна.

Өнгөрсөн долоо хоногт Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын мэдээллийн хүртээмж хариуцсан мэргэжилтэн, Keio Gijuku их сургуулийн профессор Кавамури, ASTEM хувьцаат компаний хэлтсийн дарга Кобаяши, орлогч дарга Накатани нар Монгол улс дахь мэдээллийн хүртээмжийн нөхцөл байдлыг судлахаар ирж ажиллалаа. Манай төсөл мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа тул холбогдох уулзалтуудад хамтран оролцсон юм. Кобаяши багш ASTEM компаниас гаргасан IPTV-ийн олон улсын H.702 стандартад нийцсэн SetTopBox-ийг танилцуулсан бөгөөд тус төхөөрөмжийг телевизтэй холбосноор дохионы хэлний орчуулга, үсгэн тайлбарыг нэмэлтээр оруулах, мөн дэлгэцэнд гарч буй үсгэн тайлбар, дохион хэлмэрчийн хэмжээг томруулах, байршлыг нь хүссэнээрээ өөрчлөх боломжтой. Хэрвээ хүсвэл өөрийн хэрэгцээнд тохируулан үсгэн тайлбар, дохионы хэлмэрчийг гаргахгүй байж ч болно. Тус төхөөрөмжийг Монголын Үндэсний Телевиз, харилцаа холбооны үйлчилгээний компани, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, ХНХЯ-ны холбогдох ажилтнуудад танилцуулсан бөгөөд тус төхөөрөмжийн хэрэглээг өндрөөр үнэллээ. Ялангуяа Дохионы хэлний орчуулагчдын холбоо, сонсголын бэрхшээлтэй иргэд "Бидний хэрэгцээнд нийцсэн төхөөрөмж байна!" хэмээн ихэд сонирхож байлаа.



☆Нисдэг баг - Өдрийн хоолны хүргэлтийн үйлчилгээ

2017.11.14



Монголын Дауны Холбооны залуучууд "Нисдэг баг" хоол хүргэлтийн үйлчилгээ эхлүүлэхээр ажиллаж байна. Тэд Улаанбаатар хот дахь гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагуудад хоол хүргэх бөгөөд одоогийн байдлаар 7 хоногт 2 удаа холбоон дээрээ цугларч бэлтгэл ажил хийж байна. Төслийн зүгээс өнгөрсөн 7 хоногийн Баасан гарагт тус холбооны залуучуудад Дэйзи зурагт номыг танилцуулсан юм. Нисдэг багийн гишүүд дэйзи номыг хөгжилтэйгээр сонирхон үзсэн төдийгүй өөрсдийнхөө сэтгэгдлийг ярьж өглөө. Тэдний эхлүүлсэн хоолны үйлчилгээ амжилттай болно гэдэгт итгэлтэй байна. Манай хамт олон ч бас үйлчлүүлэх болно. Бүгдэд нь амжилт хүсье!



Энэ удаа тус төхөөрөмжийг зөвхөн танилцуулах зорилгоор үзүүлсэн бөгөөд технологийн хувьд одоо ч гэсэн Монгол улсад ашиглах бүрэн боломжтой. Харин хүний нөөц бэлтгэх, холбогдох зардлыг шийдвэрлэх, тогтолцоог бий болгох зэрэг асуудлуудыг шийдвэрлэж чадвал телевизийн өргөн нэвтрүүлгүүдийг үсгэн тайлбар, дохионы орчуулгатай хүлээн авах боломж бүрдэх юм. Төслийн зүгээс цаашид мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллах болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Токиогийн олимп, пара олимпыг үсгэн тайлбар, дохионы хэлний орчуулгатайгаар хүлээн авч үзэх боломж удахгүй ирнэ гэдэгт найдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хуралдаан

2017.11.15

2017 оны 1-р сард Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн хуралдаан болж холбогдох яамдуудад дэд зөвлөл байгуулагдсан. Энэ сард ХНХЯ-ны дэд зөвлөл, Нийслэлийн зөвлөлийн хурал тус тус зохион байгуулагдлаа.

Тус хуралд ХБИ-ийн ТББ-уудын төлөөлөл, холбогдох салбарын албан хаагчид оролцож цаашид авах арга хэмжээ, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх тухай, мөн ТББ-уудын санал хүсэлтийн талаар хэлэлцлээ. Нийслэлийн зөвлөлийн хурлын үеэр төслийн ахлах зөвлөх Чибя "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц"-ийн талаар лекц тавив.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахын тулд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, дэд зөвлөлүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай. Цаашид дэд зөвлөлүүдийн хуралдаан амжилттай зохион байгуулагдаж холбогдох байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллана гэдэгт итгэлтэй байна.



"Цэг, цэг" дэйзи зурагт ном YouTube сайтад тавигдлаа. Доорх линкээр орж танилцана уу ♪

⇒<https://youtu.be/oDJPNKbf9QU>

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5,

Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com